



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

「 Хариуцлагатай жижүүр ажиллуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.4, төвийн даргын 2024 оны А/09 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.4.3, 6.6, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ :

1.Нийслэлийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг эрсдэлээс хамгаалах, төвийн байранд сахилга дэг журам, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, шуурхай арга хэмжээ авах эрх үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулсугай.

2.Хариуцлагатай жижүүрийн хувьарь, үйл ажиллагааны чиглэлийг хавсралтаар баталсугай.

3.Үйл ажиллагааны чиглэлийг баримтлан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж ажиллахыг хариуцлагатай жижүүр, ээлжийн жижүүрүүдэд анхааруулсугай.

4.Хариуцлагатай жижүүр хийсэн ажилтнуудын илүү цагийн хөлсийг журмын дагуу тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Энхдолгор)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ